



**“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР**

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027
Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,
Цахим шуудан: info@erdenetmc.mn,
Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024.06.21 № 745-124-12/4114
танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан ЭҮТӨҮГ/20240103763 дугаартай “Үйлдвэрийн газрын аюул, эрсдэл ихтэй объектуудад гамшгийн эрсдэлийн үнэлгээний ажил”-ын тендерт оролцохыг сонирхогчдоос Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр ирүүлсэн тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.

Хавсралт 1 хуудастай.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Т.БАТМӨНХ

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ГИШҮҮН

612407016144

1. Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх техникийн даалгаврын 3.2-ын Хүснэгт №01 -ийн толгой хэсгийн сүүлчийн нүдэнд “Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх төрлүүд: ...” гэснийг тодруулна уу? Тайлбар: Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7.2-д “Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд гүйцэтгэнэ” гэж заасан.

Хариулт: “Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх төрлүүд” гэснийг Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ гэж ойлгоно уу.

2.ТББ-ийн Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх техникийн даалгаврын 5 дугаар (Ажил үйлчилгээ гүйцэтгэх байгууллагад тавих шаардлага) бүлгийн 5.2 “Хоёроос доошгүй жил гамшгийн эрсдэлийн үнэлгээг уул уурхай, дэд бүтцийн салбарт хийсэн ажлын туршлагатай байх” гэж тодорхойлсон нь тусгай зөвшөөрөл нь уул уурхай, дэд бүтцийн чиглэлээр гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийхээр байгаа боловч ТББ-ийн ӨХ-н ТШЗ 19.3-д “ОБЕГ-аас олгодог гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөлтэй байх. Үнэлгээ хийх салбар: 3-р бүлгийн техникийн тодорхойлолтод заасны дагуу “Уул уурхай, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ” гэсэнтэй зөрчилдөж байгааг тодруулж өгнө үү?

Хариулт: “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ажлын туршлагад уул уурхай, дэд бүтцийн чиглэлээр ажил гүйцэтгэсэн байх ерөнхий шаардлага тавьсан. 2024 онд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх ажлын онцлогоос хамаарч тусгай шаардлагад “Уул уурхай, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ” гэж оруулж өгсөн байгаа нь зөрчилдөхгүй гэж үзэж байна.

3. Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх техникийн даалгаврын “3.Хамрах хүрээ”-нд заагдсан 12 бүтцийн нэгжийн Цахилгаан цех, Холбоо, мэдээллийн технологи, автомажуулалтын цех, Дулааны цахилгаан станц, Ус хангамжийн цех гэх мэт дэд бүтцийн объект байхад дэд бүтцийн тусгай зөвшөөрөл шаардаагүй байгааг тодруулж өгнө үү?

Тайлбар: Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам (ЗГ-ын 2020 оны 190 дүгээр тогтоолын хавсралт)-ын 4.2-д дэд бүтцийн салбарт ОБЕГ-аас олгосон “дэд бүтцийн чиглэл”-ийн тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд хийнэ.

Хариулт: Цахилгаан цех, ХМТАЦ, ДЦС, УХЦ гэх мэт дэд бүтцийн объектууд нь манай уул уурхайн үйлдвэрийн нэг салбар нэгж учраас уул уурхайн салбарт харьяалуулж ойлгоно.

4. Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг техникийн даалгаврын “3. Хамрах хүрээ”-нд заагдсан 12 бүтцийн нэгжийн аль объектод “Байгаль орчин, түүх соёлын дурсгалт газар”-ын тусгай зөвшөөрлийн чиглэлээр үнэлгээ хийхийг тодруулж өгнө үү?

Хариулт: Тодруулгын 4 дэх хэсэгт заасныг “Сэлэнгэ амралт, аялал жуулчлалын цогцолбор” гэж ойлгох.